

Огноо: 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

***БАЯБОГД БАГИЙН “ИРГЭДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ”-ИЙН БАРИЛГА УГСРАЛТЫН  
АЖЛЫН ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ***

**Төслийн нэр:** ***БАЯНБОГД БАГИЙН “ИРГЭДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ”-ИЙН  
БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ***

**Төслийн дугаар:** ДГАУБСЗДТГ/201912003

**Тендер шалгаруулалт/  
гэрээний дугаар:** ДГАУБСЗДТГ/201912003

Улаанбадрах сум  
2019 он

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

*Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Засаг даргын Тамгын газар* нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Баянбогд багийн “Иргэдэд үйлчлэх төв”-ийн барилга угсралтын ажил-ыг гүйцэтгэх** тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 10.00 цаг-аас** өмнө Дорноговь аймаг Улаанбадрах сум Засаг даргын Тамгын газар хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 10 цаг 10 минутанд** нээнэ.

**Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Дорноговь аймаг Улаанбадрах сум Засаг даргын Тамгын газар**

**Утас: 99291382, 99345660**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
    - (а) Үнийн санал. Үнийн саналд Захиалагчийн хяналтын зардлыг 2%-иар тооцож тусгаж ирүүлэх
    - (б) Оролцогч компанийн танилцуулга
    - (в) Чадварын мэдээлэл болон бусад баримт бичиг
    - (г) Ижил төрлийн ажил, үйлчилгээ үзүүлсэн туршлагын жагсаалт, холбогдох гэрээ, ажил хүлээлцсэн актын хамт
    - (д) Тусгай зөвшөөрөл
    - (е) Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар
    - (ё) Харьяалагдах банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх
    - (ж) Татвар, Нийгмийн Даатгалын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх
    - (з) Гэрээг гүйцэтгэгч удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл
    - (и) Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл
    - (й) “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14.1-д заасан нөхцөл байдал үүсээгүйг нотлох шүүх болон төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас гаргасан баримт бичиг
- 4. Тендерийн үнэ**
  - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт

үндэслэнэ.

- 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
- 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
- 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
  - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
  - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх

мэдэгдэл

ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"><li>• Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан</li><li>• Сүүлийн 3 жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, хүлээлцсэн актын хуулбар/</li><li>• Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: <b>Шаардлагатай /Барилга угсралтын ажлын тусгай зөвшөөрөл 1.2.2/</b></li></ul>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>Улаанбадрах сум, 4 дүгээр баг, Засаг даргын Тамгын газар</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>Сумын Засаг даргын орлогчийн албан өрөөнд</i> <i>04 дүгээр сарын 01-ний өдөр</i></p> <p>Цаг: <i>10 цаг 00 минутаас өмнө tender.gov.mn хаягаар</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>Улаанбадрах сум, 4 дүгээр баг, Засаг даргын Тамгын газар</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>Сумын Засаг даргын орлогчийн албан өрөөнд</i> <i>04 дүгээр сарын 01-ний өдөр</i></p> <p>Цаг: <i>10 цаг 10 минутад TENDER.GOV.MN хаягаар цахимаар нээнэ.</i></p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Баянбогд багийн “Иргэдэд үйлчлэх төв”-ийн барилга угсралтын ажил</b></p>

## Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### Улаанбадрах сумын Баянбогд багийн “Иргэдэд үйлчлэх төв”-ийн барилга угсралтын ажил:

А. Ажил гүйцэтгэх хугацааны график / хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-г тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

Б. Барилга угсралтын үе шатны ажлыг Барилгын норм ба дүрэм /БНБД/, стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

В. Үнийн саналд Захиалагчийн хяналтын зардлыг 2%-иар тооцож тусгаж ирүүлнэ.

#### **1. Суурийн ажил нь:**

Тус барилгыг цутгамал бетон шугаман суурьтай, бүс бетон хийхээр төлөвлөсөн. БМ-150

- Суурийг цутгалтын аргаар гүйцэтгэхэд хэв хашмалыг MNS3173:1981 стандартын дагуу хийх бөгөөд цутгалтанд хэрэглэх хайрга, дайрга MNS0390:1998, элсийг стандартын шаардлагад тохирсон, бетон зуурмаг нь MNS1185:1985 техникийн шаардлагыг хангасан байна. Сууринд зургийн дагуу бүс бетон цутгаж хийнэ. БМ-150

- Барилгын газар шороо буйр суурийн ажлыг гүйцэтгэхэд БНБД 3.02.01-90-г баримтална.

- Цутгалтын ажил гүйцэтгэхэд БНБД 3.03.02-90-г баримтална

- Суурийн нүх ухагдаа суурь суух түвшингээс илүү ухахгүй байхыг анхаарах.

#### **2. Өрөгт бүтээцийн ажил нь:**

Өргийн ажлыг гүйцэтгэхдээ БНБД 3.03.05-90-г баримтална. Гадна ханыг 38 см-ийн тоосго, хамар ханыг 12 см-ийн улаан тоосгоор өрнө. Ханыг зурагт заасны дагуу арматурчлаж өгнө. Ханы дээр эргэн тойрон бүс бетоныг зураг төслийн дагуу цутгаж хийнэ. БМ-150

#### **3. Хаалга, цонхны ажил нь:**

- Хаалгыг БНБД 3.03.08-88 дагуу гүйцэтгэх ба модон эдэлхүүний материалд улсын стандарт MNS3944:1998-г мөрдөнө. Цонх нь хуванцар рамтай давхар шилтэй салхи шорооноос хамгаалсан резин хамгаалалт нь стандарт шаардлагыг хангасан байна. Дулаан дамжуулалтын эсэргүүцэл  $R=0.7$  м<sup>2</sup>.град/ватт-аас багагүй байх шаардлагатай. Цонхны эргэн тойронд тэлдэг хөөсөн чигжээсээр дулаална. Цонхонд хиймэл гантгиг чулуун тавцан суулгах ба мөн гадна талд усны хаялга төмөр угсарч өгнө.

-Хаалга, цонхыг эрх бүхий байгууллагаар захиалж хийлгэнэ. Гадна хананд чанарын шаардлага хангасан төмөр хаалга суулгана.

#### **4. Шалны ажил нь:**

- Шалны шороог сайтар нягтруулж 10 см-ын бетон тэгшилгээний ажлыг БНБД 3.04.04-90 дагуу гүйцэтгэнэ.

- Бетон дэвсгэрт тэгшилгээ тусгаарлалт хийж хиймэл чулуун хавтанцар шал хийнэ. Чулуун хавтанцар шалны гадаргуу хальтирдаггүй барзгар байна. Чулуун шал нь чанарын шаардлага хангасан, 1.5см-2см-ийн зузаантай байна.

#### **5. Дотор цахилгааны ажил нь:**

-Цахилгаан мантожийн угсралтын ажлыг гүйцэтгэх үед БНБД3.05.06.-90-г мөрдлөг болгоно. Цахилгааны холболтын ажилд ППВ-2х2.5 мм<sup>2</sup> маркийн зэс голтой утас хэрэглэнэ. Цахилгааны материалууд нь чанартай стандартын шаардлага хангасан байна.

- Унтраалга, разетка нь чанартай стандартын шаардлага хангасан байна. Хятад улсад үйлдвэрлэсэн цахилгааны монтажкийн утас хэрэглэхийг хориглоно.

- Дотор цахилгааны утасыг хамгаалалтын хоолойд сүвлэх, яндан хоолойг угсрах, шавардлагын доорхи далд монтажкийн утсыг татаж бэхлэх ажлыг угсралтын ажилтай хамт гүйцэтгэнэ.

## **6. Хучилт, дээврийн ажил нь:**

- Дээврийн модон хучилтыг зураг төсөлд заасны дагуу хийнэ. Банзан хучилтын дээр дээврийн уур тусгаарлагчийг хар цаасаар хийж шилэн хөвөн дулаалага хийж банз бруссээр хамгаалалт хийж байна. Дээврийн модон хийц нь чанарын шаардлага хангасан байна. Дээврийн ажлын модон хийцэд галаас хамгаалах түрхлэгийг заавал түрхэж өгнө.

- Дээврийн ажлыг зураг, төсөвт тусгагдсаны дагуу гүйцэтгэнэ.

## **7. Заслалын ажил:**

Гадна дотор хуурай ба нойтон шавардлага, будаг, цааслалт, шиллэгээ, өнгөлгөөний ажилд БНБД31-10-05-г мөрдөнө.

Гадна агаарын температур +8 хэмээс багагүй, өрөөний температур +10 хэмээс багагүй үед заслалын ажил гүйцэтгэнэ.

Дотор ханын шавардлага хийх гадаргууг сайтар зүлгэж технологийн дагуу бэлтгэсний дараа сайн чанарын тэгшилгээ хийж 1.6 м өндөрт тосон будгаар үлдсэн хэсэгт эмульсэн будгаар технологийн дагуу будна.

Дотор засварын ажилд БНБД3.04.02-88-г мөрдөнө. Заслалын ажилд хэрэглэх материалууд нь MNS5252:2003, MNS4584:98, MNS4581:2003 техникийн шаардлага хангасан байна.

- Цонхны амалгааны засварын ажилд БНБД3.04.02-88-г мөрдөнө.

Дотор заслалын ажилд хэрэглэгдэх материал нь чанарын шаардлага хангасан байна.

## **8. Халаалтын ажил:**

Ердийн халаах ханатай пийшинг жижиг өрөөнүүдэд, зааланд мөн пийшин байрлуулж ф250мм-ийн яндагаар холбож халаалтыг хийнэ. Утааны яндаг тоосгоор өрж хийнэ.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификад, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонон авбал “Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ”, лабораторийн шинжилгээний дүн, падаан хавсаргана.

Угсралтын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд гүйцэтгэсэн ажилдаа Барилгын тухай хуулийн 12.4-ын дагуу 36 сарын баталгаа гаргаж өгнө.

Хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.

Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.

Дээрх техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын Улсын байцаагч эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.


Үнийн саналыг тооцож ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлэх. Үнийн саналд Барилга хот байгуулалтын сайдын 2012 оны 181 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, ашиг, техник хяналт, нормчлолын сан, НӨТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД “ҮҮ”81-95-12-г мөрдлөг болгоно.

**Тав. Ажлын тоо хэмжээ**

Ид	Ажилбарын нэр	Хэмжих нэгж	Тоо
<b>01. Газар шорооны ажил</b>			
1	Байгалийн хөрсийг гараар нүдэн баримжаагаар тэгшлэх 2-р зэргийн хөрс	м2	220.00
2	Суурийн н/х гараар ухах	м3	36.62
3	Шуудуу хүнхээл нүхийг 2-р зэргийн хөрсөөр эргүүлж булах	м3	0.00
4	Түрдэг тэргээр шороо зөөж шалан доор 150-200мм хүртэл зузаантай дэвсгэр үе хийж нягтруулах	м3	15.93
5	1-3-р зэргийн хөрсийг гараар тэгшлэх	м3	15.93
6	Ургамлын хөрсийг гараар хуулах	м3	33.00
<b>02. Суурийн ажил</b>			
7	Бетон шугаман суурь цутгах М150	м3	6.70
8	Хэв хашмалтай бүс төмөр бетоноор цутгах М-150	м3	4.45
9	Бетон ба дэвсгэр үеийг арматурчилах	тн	0.32
10	Сууринд хажуугийн ус тусгаарлагч битум түрхлэгээр 2 үе хийх	м2	30.52
11	Сууринд хэвтээ ус тусгаарлагч шингэн шилтэй цементэн зуурмагаар хийх	м2	17.44
<b>03. Ханын ажил</b>			
12	Гадна 380 мм-ийн тоосгон хана өрөх	м3	35.72
13	1/2-ын тоосгоор хана арматургүй өрөх	м2	27.94
14	2,5м хүртэл урт модон ялуу угсрах	ш	15.00
15	Тоосгон өрөг арматурчлах	тн	0.06
16	Хэв хашмалгүй бүс төмөр бетоноор цутгах М-150	м3	2.23
<b>04. Хаалга цонхны ажил</b>			
17	2м2 хүртэл талбайтай давхар шилтэй хуванцар рамтай цонх угсрах	м2	10.80
18	Гадна дотор тоосгон хананд 3 м2 хүртэл талбайтай хаалга усрах	м2	7.98
19	Хаалганд цоож суулгах	ш	5.00
20	2м2 хүртэл талбайтай бүргэд хаалга суулгах	ш	2.00
21	Хаалганы зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжих	м2	7.98
22	Цонхны зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжиж дулаалах	м2	10.80
23	Цонхонд хиймэл чулуун тавиур суулгах	м2	1.00
<b>05. Шалны ажил</b>			
24	Бетоны дэвсгэр үе хийх БМ -100	м3	7.97
25	1м2-д 3-хүртэл ширхэг гантиг чулуун хавтан дэвсэж шал хийх	м2	79.65
<b>06. Заслалын ажил</b>			

Д/д	Ажилбарын нэр	Хэмжих нэгж	Тоо
26	Дотор тоосго ба бетон ханыг шохойн зуурмагаар гараар сайн чанартай шавардах	м2	138.75
27	Хананд замаск хийх	м2	138.75
28	Хаалга, цонхны амалгааг чанартай шавардах	м2	10.10
29	Таазанд гипсэн хавтан угсрах	м2	79.65
30	Таазанд замаск хийх	м2	79.65
31	Хана эмульсэн будгаар будах	м2	49.95
32	Тааз эмульсэн будгаар будах	м2	79.65
33	Шаврдсан хана өнгийн тосон будагаар гар аргаар сайн чанартай будах	м2	88.80
<b>07. Бусад ажил</b>			
34	Гал тогооны тоосгон ханатай пийшин барих	м3	1.45
35	Пийшингийн утааны яндан барих	м3	0.45
36	Цонхны ялуу өнгийн тосон будгаар будах	м2	7.79
37	Модон ялуу гараар сайн чанартай шавардах	м2	7.75
38	Бетон довжоо цутгах М-100	м3	0.72
39	Бетон хаяавч цутгах М-100	м3	4.00
40	Хаяавч довжоонд цементэн өнгөлгөө хийх	м2	40.14
<b>08. Дотор цахилгаан</b>			
41	Гэрэлтүүлгийн самбар угсрах	ш	1.00
42	1*2.5мм2 хүртэл хөндлөн огтлолтой зэс голтой ПВХ тусгаарлагчтай утас	м	550.00
43	хуванцар хоолой угсрах Д-20 мм 2	метр	100.00
44	Далд угсрах ердийн нэг туйлт унтраалга тавих	ширхэг	3.00
45	Хоёрлосон унтраалга тавих	ширхэг	2.00
46	Далд угсрах хамгаалагдсан разетка тавих	ширхэг	6.00
47	Розетка унтраалагын блок угсрах	ш	11.00
48	2 хүртэл ламптай хасах өдрийн гэрэлтүүлэгч таазанд угсрах	ш	9.00
49	5Гэрлийн утасны хамгаалалтын хуванцар хар хоолой угсрах. Д-20 мм2	метр	550.00
<b>09. Хучилт, дээврийн ажил</b>			
50	Тоосгон ханатай барилгын бамбайн зулавчтай модон хучилт хийх	м2	87.24
51	Дүнзэн дан тулгуур, холбоос ба дам нуруу угсрах	м3	1.74
52	Банзан шувуу нуруу угсрах	м3	1.14
53	Цэвэр банзан карниз угсрах	м2	25.61
54	Харуулдсан банзан фронтон угсрах	м2	12.80
55	Модон сараалжтай долгионт төмөр дээвэр хийх	м2	110.88
<b>10. халаалт</b>			
56	Халаалтын ган яндан угсрах голч d=250мм	м	8.00
57	Зөөврийн төмөр пийшин суурилуулах	ш	1.00
<b>99. Хог хаягдлын дүн</b>			
58	Хог хаягдал	тн	0.00

1-р давхарын зай хэмжээний байгуулалт



ТАНИХ ТЭМДЭГ


	ЕРДИЙНЛИМ ТООСОН ХАНА 30ММ
	ЕРДИЙНЛИМ ТООСОН ХАНА 120ММ
	ЕРДИЙНЛИМ ТООСОН ХАНА 60ММ

Өрөө тасалгаа ба засалын ажлын тодорхойлолт

Д/д	Өрөө тасалгааны нэрс	Талбай м <sup>2</sup>	Хянах төрөл
1	КОРИДОР	9.2 м <sup>2</sup>	чулуу эмгэс
2	ЗМЧИЙН ӨРӨӨ	8.8 м <sup>2</sup>	чулуу эмгэс
3	ДАРГЫН ӨРӨӨ	8.95 м <sup>2</sup>	чулуу эмгэс
4	ЗААЛ	52.7 м <sup>2</sup>	чулуу эмгэс
		<b>ДҮН</b>	<b>79.65 м<sup>2</sup></b>

		Дотоодын ажил үйлчилгээний сүлжээний дэвсгэрт "МЭТГЭДЭД ҮЙРЧЛЭХ ТӨВИЙН БАРИГА"		<b>БА</b>
Зардал	С.Ахилбаатар	1-р давхарын зай хэмжээний байгуулалт	Масштаб: 1:75	Тусгай
Алиментатор	О.Туушьяагвар			Ажлал
Гүйцэтгэсэн	О.Туушьяагвар	ЕТ Шийрэг: МТ-201603001		03
Шалгалсан	Т.Т.Шарваг			10
				2016 он 03 сар

1-р давхарын технологийн байгуулалт



ТАНИХ ТЭМДЭГ	
	ЕРДИЙН УЛИАНТООСГОН ХИНА 300ММ
	ЕРДИЙН УЛИАНТООСГОН ХИНА 120ММ
	ЕРДИЙН УЛИАНТООСГОН ХИНА 60ММ

Өрөө тасалгаа ба засалгын ажлын тодорхойлолт

Д/д	Өрөө тасалгааны нэрс	Талбай м2	Шалны төрөл	Хөвөн төрөл
1	КОРИДОР	9.2 м2	чулуу	ангилс
2	ЗМЧИЙН ӨРӨӨ	8.8 м2	чулуу	амгала
3	ДАРГЫН ӨРӨӨ	8.95 м2	чулуу	амгала
4	ЗААЛ	52.7 м2	чулуу	амгала
		<b>ДҮН</b>	<b>79.65 м2</b>	

**МТ CONSTRUCTION**  
"МТ Констракшн" ХХК

Дорнод аймаг Увс-Баянхонгор сум Сөгөлө дундай баг "ИРГЭДЭД УЙТЧИЛЭХ ТӨВИЙН БАРИЛГА" -

Замрал: С.Арчибаатар  
 Архитектор: О.Тувишбилэг  
 Гүйцэтгэсэн: О.Түвшинбаяр  
 Шалгарсан: Т.Т.Ширээр

Масштаб: 1:75  
 Үзэж: Хуучин  
 АЗ: 04  
 2018 он 03 сар



**Дотор заслын ажлын тодорхойлолт**

Дэвсгэр	Өрөөны дугаар	Тааз		Хана, хамар хана	
		Засгалын төрөл	Засгалын төрөл	Засгалын төрөл	Засгалын төрөл
1-р дэвсгэр	1.2.3.4	Замаск тэгшилгээ Цагаан өнгийн эмүүльсэн будгаар 2 дахин будна.	Сайжруулсан шавардлага Замаск тэгшилгээ Цайвар шаргал өнгийн эмүүльсэн будгаар 2 дахин будна		

Хаалганы түүвэр			
Х-1	Х-2	Х-3	ХБ 21-9
Зүүн 1 ширхэг	Зүүн 1 ширхэг	Зүүн 1 ширхэг	Баруун 1 ширхэг

Цонхны түүвэр	
Ц 12-15	6 ширхэг

**Шалны бүтэц**

Өрөөны дугаар	Шалны төрөл	Шалны огтлол	Шалны бүтэц
1.2.3.4	Чулуу		Чулуу /Маталог-С/ зуу. 8мм. 600х600мм Цементэн зуурмаг М-100 зуу. 20мм Тортгой бетон.


**MT**  
CONSTRUCTION

Дорноговь аймаг Улаанбаатар сум Сөгчидүрвэй баг  
"ИРТЭДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВИЙН БАРИЛГА"  
Замарал С.Арьяабаяр  
Ариунтосгор О.Түвшинбаяр  
Гүйцэтгэсэн И.Г. Ширээт  
Цонх халтаны материалын түүвэр  
Шийрэг: МТ-2016/03/01

Масштаб: 1:100  
Угшилт: 10  
Аж: 07  
10  
БА



<b>МТ</b> CONSTRUCTION МТ Констракшн ХХК		Дорнод аймаг Улаанбаатар орон Сүхбаатар дүүрэг "ИРГЭДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВЧИЙН БҮРГИЛГЭ" *		<b>БА</b>	
Засраал	С.Ариунбаяр	Нүүр тал	Масштаб: 1:75	Үндэс	Бие өсөөг
Архитектор	О.Түвшинбаяр	ЕГ Шийрэг: МТ-201600001	А3	02	10
Гүйцэтгэсэн	О.Түвшинбаяр	ТТ Шийрэг:	2018 он 02 сар		
Шалтгаан					



Поэ	Тэжээлгээ	Нэр	Тоо	Хүрч мкг	Тайт
<b>Цутгал шалны суурь материалын түүвэр</b>					
1	Ø16 А400	L=277	У.м	543.3	437.2
2	Ø8 А240	L=1280	210	0.5	108.1
Цутгал шалны материалын түүвэр				554.9	
3	Ø10 А240	L=900	У.м	554.9	554.9
Материал В12.5				V=6.2м3	
<b>Гадна дооноосны материалын түүвэр</b>					
4	Ø10 А240	L=43.2	У.м	26.6	53.3
Материал В12.5				V=0.36м3	
<b>Хавачны материалын түүвэр</b>					
Материал В12.5				V=4.0м3	

Төвлөбөр  
 Өмгөлд өндөржилтийн зурагт хийгдээгүй болно.  
 Өөр хөлдүү хөрсөнд суулгахыг хориглоно.  
 Өөр хөлдүү хөрсөнд суулгахыг хөлдүү хөрсөөр хийхийг хориглох бөгөөд гэсэлэн хөрс байх шаардлагатай.  
 Өөр хөлдүү хөрсөнд суулгахыг хөлдүү хөрсөөр хийхийг хориглох бөгөөд гэсэлэн хөрс байх шаардлагатай.

**MT CONSTRUCTION**

Бүтээгдэхүүн: Уламжлалт үйлдвэрлэл  
 "МРГЭЗЭД ҮЙЛДЭХ ТӨВРИЙН БАРИЛГА"

Зархал: А.Уугуйвар  
 Инженер: А.Уугуйвар  
 Гүйцэтгэсэн: А.Уугуйвар

Сурьтын байгуулал: ЕГ Шийрэг МТ-20160301

ББ

Масштаб: 1:25; 100

Тоо: 09  
 Хуудас: 09  
 Төв: 10

## Зургаа. ЖИШИГ МАЯГТ

### ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Долоо. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |                                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
|-------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.                                                                                                                                                                 |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
| <b>Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</b>                    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>                                    | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.<br>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b>                         | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.                                                                                                                                                                                                |
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>                          | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.<br>9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн                                                                                                                                                                                                        |

- мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх** 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

- 11. Үе шатны ажлын хуваарь** 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх** 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги** 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

- 14. Ажил дуусгах** 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.